МЭДЭЭ · 2025 оны 2-р сарын 28


"ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГЫН АЖИЛТНЫ ЁС ЗҮЙ" СЭДЭВТ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Монгол Улсын засгийн газрын 2024 оны 109 дүгээр тогтоолоор "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ"-г баталсан. Уг хэм хэмжээнд төрийн албан хаагчийн хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд баримтлах ёс суртахууны нийтлэг шаардлага, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, эс үйлдэхүй болон ёс зүйн хариуцлагын талаар тусгасан байдаг.



Улсын ерөнхий прокурорын газрын дэргэдэх Сургалт, судалгааны хүрээлэнгээс Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг мөрдлөг болгож, ёс зүйн алдаа дутагдал гаргахгүй байхад анхаарах, эерэг харилцаа хандлагыг төлөвшүүлэх хүрээнд нийт прокурор, ажилтнуудад "Прокурорын байгууллагын ажилтны ёс зүй" сэдэвт сургалтыг зохион байгуулж, 500 гаруй прокурор, ажилтан оролцуулжээ.



Тус сургалтаар Төрийн албаны зөвлөлийн гишүүн, Ёс зүйн хорооны дарга Ц.Амартөгс, Удирдлагын Академийн хүний нөөцийн тэнхимийн профессор, доктор Н.Цолмонтуяа нар “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль”, “Төрийн албаны үнэт зүйлс ба төрийн албан хаагчийн ёс зүй” сэдвээр мэдээлэл өгч, оролцогчид ёс зүй, ёс суртахууны тухай ойлголт, төрийн албан хаагчийн харилцааны ёс зүй, анхаарах асуудлын талаар ярилцаж, сонирхсон асуултдаа хариулт авсан байна.



Эх сурвалж: https://prosecutor.mn/post/1098